

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 25-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООДЫН
ХАМТАРСАН

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 – 14

- “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын
1. тогтоолын төсөл /Засгийн газар 2025.11.19-ний өдөр
өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

5 – 14

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн болон Төсвийн байнгын хороодын
11 дүгээр сарын 25-ны өдөр /Мягмар гараг/-ийн хамтарсан
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Д.Үүрийнтуяа ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хамтарсан хуралдаанд ирвэл зохих 54 гишүүнээс 28 гишүүн хүрэлцэн ирж, 51.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 41 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Баясгалан, Б.Бат-Эрдэнэ, Б.Бейсен, Г.Ганбаатар, С.Ганбаатар, Д.Жаргалсайхан, Ж.Чинбүрэн, Х.Ганхуяг, Ч.Номин, Б.Түвшин;

Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, С.Амарсайхан, П.Батчимэг, Л.Мөнхбаясгалан, З.Мэндсайхан, У.Отгонбаяр, Ц.Даваасүрэн, П.Сайнзориг;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Булгантуяа, Ж.Ганбаатар, Д.Пүрэвдаваа, Да.Цогтбаатар;

Тасалсан: Н.Алтанхуяг, П.Мөнхтулга, З.Мэндсайхан, Д.Энхтүвшин.

Нэг. “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2025.11.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн газрын Салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн Х.Цэрэнханд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх Бад.Баярмаа, Ж.Түвшинжаргал, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт С.Төрмөнх нар байлцав.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабалын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ж.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Золжаргал, Б.Мөнхсоёл нар үг хэлэв.

Д.Үүрийнтуяа: “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 17

Татгалзсан: 12

Бүгд: 29

58.6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддоржийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 62.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 12 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хамтарсан хуралдаан 23 минут үргэлжилж, 54 гишүүнээс 28 гишүүн хүрэлцэн ирж, 51.8 хувийн ирцтэйгээр 12 цаг 04 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН,
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Х.ГАНХУЯГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхим
11 цаг 41 минут

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БОЛОН ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООДЫН ХАМТАРСАН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Үүрийнтуяа: Байнгын хороодын эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны гишүүдийн олонх ирж Байнгын хороодын ирц 51.9 хувь бүрдсэн тул 2025 оны 11 сарын 25-ны өдрийн хамтарсан хуралдаан нээснийг мэдэгдье. /алх цохив/

Ирцэд орсон гишүүд танхимдаа цуглахыг хүсье.

Гишүүдийн ирцийг танилцуулъя.

Наранцэцэгийн Алтаншагай, Далайн Батбаяр, Жадамбын Батсуурь, Мөнгөнцогийн Ганхүлэг, Батжаргалын Заяабал, Сүрэнжавын Лүндэг, Тогтмолын Мөнхсайхан, Салдангийн Одонтуяа, Агваанлуvsангийн Ундраа, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Очирбатын Амгаланбаатар, Ринчиндоржийн Батболд, Хөххүүгийн Болормаа, Гонгорын Дамдинням, Жаргалсайханы Золжаргал, Мэндбаярын Мандхай, Баатаржавын Мөнхсоёл, Цэвэгдоржийн Туваан, Болдын Уянга, Тилеуханы Аубакир, Жигжидийн Батжаргал, Пүрэвжавын Ганзориг, Сонгобайн Замира, Цагаанхүүгийн Идэрбат, Цагаанхүүгийн Мөнхбат, Нанзадын Наранбаатар, Ганзоригийн Тэмүүлэн, Баттогтохын Чойжилсүрэн гэсэн гишүүд хүрэлцэн ирсэн байна.

Хамтарсан хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Засгийн газрын 2025 оны 11 сарын 19-ний өдөр өргөн мэдүүлсэн “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэхийг хэлэлцэж санал, дүгнэлтээ нэгдсэн чуулганд танилцуулна.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Саналтай гишүүд алга байна. /алх цохив/

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хэлэлцэж эхэлье.

Нэг. “Тогтоолд нэмэлт оруулах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төсөл
/Засгийн газар 2025.11.19-ний өдөр өргөн мэдүүлсэн,
хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтныг танилцуулъя.

Жадамбын Энхбаяр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Цэндгомбын Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Хурцаагийн Цэрэнханд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Бодлого, төлөвлөлтийн газрын салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн гэсэн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирсэн байна.

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Жадамбын Энхбаяр танилцуулна.

Ж.Энхбаяр сайд 5 номерын микрофоныг өгье.

Ж.Энхбаяр: Эрхэм Байнгын хорооны дарга, гишүүд ээ,

Манай улсын газар тариалан, мал аж ахуй, хүнсний салбарын үйл ажиллагаа нь уур амьсгалын өөрчлөлт болон олон улсын харилцаанаас үүдэн гарсан үр дагаврууд, эдийн засгийн таагүй нөлөөнд мэдрэг байсаар байгаа бөгөөд цаашид ч үүсэж болзошгүй нөхцөл байдлыг харгалзан үзэж цаг үеийн шинжтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр гаалийн албан татвартай холбоотой хууль тогтоомжийг өргөн мэдүүлсээр ирсэн.

Тухайлбал, өвөлжилт, хаваржилтыг хүндрэлгүй даван туулах, хүн амын хүнсний хангамж, хүртээмжийн тогтвортой байдлыг хангах, стратегийн хүнсний нөөц бүрдүүлэх зорилгоор 2014-2025 он оны хооронд улаан буудай, улаан буудайн гурил болон малын тэжээлийг гаалийн албан татвараас чөлөөлөх хүрээнд нийт 8 удаа тусгайлан хууль гаргаж зохицуулж ирсэн байна.

Улмаар Монгол Улсын Их Хурлын 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн чуулганаар мал аж ахуйн салбарыг эрсдэлээс хамгаалах, гол нэрийн бүтээгдэхүүний хангамж, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах, нөөцийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх зорилгоор импортлох мал, амьтны тэжээл, тэжээлийн нэмэлт болон улаан буудайн гурилыг Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хэлэлцэн баталсан.

Дээрх хуулийн хэрэгжилтийн хүрээнд гурилын нийлүүлэлт нэмэгдэж, үнэ тогтворжсон эерэг үр дүн гарсан боловч энэ нь улаан буудайн гурил үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нөлөөлөөд зогсохгүй манай улсын эдийн засгийн тулгуур салбаруудын нэг болох хөдөө аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлж, цаашлаад салбарын хэмжээнд үйлдвэрлэлийн тасалдал үүсгэх нөхцөл байдал бүрдсэн.

Улмаар Монгол Улсын Их Хурал 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн чуулганаар дээрх арга хэмжээг зогсоож, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэн баталсан билээ.

2025 оны байгаль, цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан баруун бүсийн хэмжээнд хур тунадас бага, гантай байснаас улбаалан байгалийн хадлан, өвс тэжээлийн гарц муу, улаан буудайн тариалалт, ургац хураалт өмнөх жилүүдээс харьцангуй бага байх төлөвтэй зэрэг тариалангийн үйлдвэрлэлийн бодит нөхцөл байдалд тулгуурлан улаан буудайн гурил, мал амьтны тэжээл, тэжээлийн нэмэлтийн хангамж, нийлүүлэлт тухайн бүс нутагт доголдох нөхцөл байдал үүсэж болзошгүй байна.

Иймээс баруун бүсийн нөхцөл байдалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Жангабыл болон нэр бүхий Улсын Их Хурлын 64 гишүүнээс Баян-Өлгий аймгийн Цагааннуур, Ховд аймгийн Ярант, Увс аймгийн Боршоо, Завхан аймгийн Арцсуурь, Говь-Алтай аймгийн Бургастай боомтоор улаан буудайн гурил, малын тэжээл, тэжээлийн нэмэлтийг импортлох боломжоор хангаж, гаалийн албан татвараас чөлөөлж, иргэдэд бодитой дэмжлэг болгохыг хүссэн санал, хүсэлтийг ирүүлээд байна.

Иймд хөдөө аж ахуйн салбарт үүссэн бодит нөхцөл байдал харгалзан үзэж, алслагдсан бүсийн хүн амын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нэг болох улаан буудайн гурилын хангамж, нөөц тасалдахгүй байх, байгаль цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалсан малын тэжээлийн хомсдол, үүсэж болзошгүй хүндрэлийг даван туулахад тухай бүр Засгийн газрын хүрээнд шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан өргөн барьж байна.

Төслийг хэлэлцүүлэн шийдвэрлэж өгнө үү. Баярлалаа.

Д.Үүрийнтуяа: Ж.Энхбаяр сайдад баярлалаа.

Танилцуулгатай холбоотой асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү.

Б.Заяабал гишүүнээр тасаллаа. Ирцийн дарааллын дагуу Б.Заяабал гишүүн асуултаа асууя.

Б.Заяабал: Гишүүддээ өглөөний мэндийг хүргэе.

Тэгэхээр сүүлийн 8 дахь удаагаа гурил тэжээлийг импортын татвараас нь чөлөөлөх тогтоолыг Их Хурал баталж байгаа гэсэн танилцуулга оруулж ирж байна л даа.

Энэ дээрээс нь холбоотойгоор би баруун бүсийн хүнсний тэжээл, гурилыг ер нь тогтвортой хангах, цаашид ийм зүйл гаргахгүй байх тал дээр Хөдөө аж ахуйн яамны бодлого нь юу байгаа юм бэ гэдэгтэй холбоотой асуудал би асуух гээд байгаа юм.

Өнөөдөр баруун бүс нутагт 3 жилд нэг удаа давтамжтайгаар гангийн байдалтай, байгаль, цаг уурын эрсдэлд байнга тулж ирж байгаа. Сүүлийн жилүүдийн ган, зудын мэдээллийг аваад үзэх юм бол дандаа 3 жилд нэг удаа давтагдаж байгаа.

2024 онд айхтар хаврын зуд болсон. Монгол орон даяараа мэдэж байгаа. Ялангуяа баруун бүс нутаг, зүүн бүс нутаг дээр нэлээн хүнд цохилт ирсэн. Энэ жил дахиад хоёр дахь жил дээрээ хоёр жилд нэг удаа дахиад гангийн асуудал орж ирж байна.

Гантай холбоотойгоор өнөөдөр баруун бүс нутаг Увс аймагт байдал аягүй хүнд байгаа. Бог малын хувьд харьцангуй гайгүй. Бодын хувьд идэх өвс байхгүй. Адуу босоогоороо үхээд эхэлсэн байна шүү дээ. Адуу босоогоороо үхээд эхэлсэн байна.

Бүсүүдийг нь аваад үзэх юм бол хамгийн их мал аж ахуйтай бүс манай баруун бүс байгаа юм.

Тэгэхээр бүрэн эрсдэлийн цаг уурт амьдардаг бүс нутгийг хангахын тулд зайлшгүй газар тариалан, тэжээлийн ургамлыг нь дэмжиж өгөхөөс өөр арга байхгүй.

Өнөөдөр Увс аймгийн Баруунтуруун суманд 40 мянган эргэлтийн га талбай байгаа. Одоо 10 мянган га орчмыг л ашиглаж байгаа. 2, 3 жилийн өмнө, 5 жилийн өмнө 20 мянган га-г нь ашигладаг болсон байсан. Одоо буцаад буучихлаа.

Тэгэхээр төрийн дэмжлэг юу байх юм бэ гэдэг. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь, хамгийн гол нь газар тариаланг дэмжих, тэжээлийн ургамлыг дэмжихийн тулд усжуулалтын асуудлыг шийдэх зайлшгүй шаардлага байгаа юм.

Увс аймгийн хувьд хөв цөөрөм үүсгэх, голуудыг хааж боогоод хөв цөөрөм үүсгэх асуудал яригдаад байдаг л даа. Гэтэл урсаж байгаа гадаргын ус, гол мөрөнөөс суваг шуудуу татах хэлбэрээр усжуулалтын талбайг бас нэмэгдүүлэх шаардлага байна уу гэж харж байгаа. Тэсийн их голоос наашаа 20, 30 километрийн суваг татаад Баруунтурууны 40, 50 мянган га-г эргэлтэд оруулах боломж байгаа юм. Энэ дээр Хөдөө аж ахуйн яам ямар бодлого барьж байгаа юм бэ гэдэг дээр би онцгойлж анхаарах гээд байгаа юм.

Тэгээд үндсэндээ жил жилийн, хоёр жилд нэг удаа давтамжтай, хоёр жилд нэг удаа ийм байдал цаашаа бодлого аваад яваад байх юм бол энэ бүс нутагт газар тариалан, тэжээлийн ургамал хөгжих ямар ч боломжгүй болоод байна. Социализмын үед цагтаа бүрэн хангадаг байсан шүү дээ.

Д.Үүрийнтуяа: Ж.Энхбаяр сайдын микрофоныг өгье.

Ж.Энхбаяр: Баруун бүс нутагт өвөлжилт хүндэрч байгаа.

Гэхдээ энд нэг зүйлийг онцлон хэлмээр байгаа юм.

Одоо бүгдийг байгаль руу буруутгахаа бүгдээрээ болих хэрэгтэй. Сая Б.Заяабал гишүүн их чухал юм ярьж байгаа юм. Одоо ингээд 8 удаагийн хуулийн зохицуулалт хийгээд, баруун бүс нутагт хөнгөлөлттэй, татварын чөлөөлөлттэй гурил, малын тэжээл оруулах асуудлыг зохицуулж ирсэн байна.

Яам бол үүний эсрэг байгаа. Эрх зүйн орчин тогтвортой байж тэнд улаан буудайн тариалалт, гурил үйлдвэрлэл, малын тэжээлийн үйлдвэрлэл тогтвортой байх тэр эдийн засгийн нөхцөлийг нь л бүрдүүлэх гол орон зай нь энэ татварын бодлого байгаа юм.

Ийм ч учраас эрх зүйн орчин тогтворгүй байгаа учраас тэнд хөрөнгө оруулахгүй байна. Тэнд Баруунтурууний сангийн аж ахуй социализмууд баруун 5 аймгийг бүрэн хангаж байсан тэр аж ахуйг босгох зайлшгүй бодлого хэрэгтэй байдаг. 30 гаруй мянган га талбай хоосон байна. 30 мянган га-д тэжээлийн таримал тарихад баруун бүс нутагт зуд гэдэг ойлголт үндсэндээ дуусна. Энэ чиглэлээр аймгуудад бид шаардлага 4 дэхээ явуулж байгаа.

Аймгийн удирдлагуудад. Бас анхаарах хэрэгтэй. Тэжээлийн талбайгаа нэмэгдүүлээч ээ. “Атрын-4” аяны хүрээнд 200 мянган га талбайг нэмэгдүүлж байгаа гол зорилго нь уламжлалт мал сүргийг байгаль цаг уурын хүндрэл эрсдэлээс хамгаалах, малын тэжээлийн таримлыг Монгол Улсын хэмжээнд тарих бодлого байхгүй юу даа.

Зуд болохоор улсын төсвөөс –

- мөнгө авдаг,
- тэтгэмж авдаг,
- тусламж авдаг –

-тэгээд буцаад бахь байдгаараа байдаг биш.

Өнөөдөр тэжээл тарьсан нутаг орон, малчинд хоршоод, фермерүүд, аймаг орон нутаг, зуд гэдэг ойлголт байхгүй. Метр цас орсон ч малаа тэжээгээд л өнтэй сайхан давж байна.

Тэгэхээр бид энэ бодлого руугаа л тууштай эргэлт буцалтгүй ормоор байна.

Нөгөө талаар яамны бодлого баруун бүс нутгийг эрсдэлээс хамгаалах нь гол зорилго. Гэсэн хэдий ч Улсын Их Хурлын төсөв дээр өргөн барьсан төсөв, боломж маш хязгаарлагдмал байгаа.

Сая өргөн барьсан төслөөс бид 90 гаруй тэрбумаар хасагдсан. Баруун бүс нутгийн газар тариаланг сэргээх гол бодлогын олон зорилтууд үүнтэй холбоотойгоор бас л хойшлох ийм л төсөв баталсан шүү дээ.

Тэгэхээр тэжээл. Ерөөсөө л дахин хэлмээр байна. “Тэжээл”.

Тэжээлийн таримлыг бид бүх улсын хэмжээнд, бүх мал аж ахуйн хэмжээнд

—

- тарьдаг,
- ургуулдаг,
- малаа тэжээдэг болж байж –

— эрсдэлгүй болно, мал аж ахуй эрчимжинэ, хөгжинө, бүтээмжтэй болно.

Сайн сайн жишээнүүд олон байна. Нэг үеэ бодвол бас –

- тарьдаг болж байна,
- ургуулдаг болж байна,
- шинэ тэжээлэн тарималуудыг нутагшуулж байна,
- сайн үр дүнгүүд гарч байна.

Тэгэхээр энэ бодлогыг л бүгдээрээ цаашдаа тууштай явъя.

Гэхдээ энэ зохицуулалт одоо ингээд бид татварыг тэглэх асуудал биш шүү дээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд одоо ингээд шийдэх байх.

Их Хурлын 40 гаруй гишүүн санаачлаад ороод ирэхээр бид оруулж ирэхээс аргагүй улс төрийн байдал үүссэн.

Уг нь энэ татварын бодлоготойгоо тууштай үйлдвэрлэлээ хамгаалах бодлогыг хийх л учиртай юм даа гэж яамны байр суурь бол тийм байгаа.

Тэгээд үнэхээр гэнэтийн эрсдэл үүсээд ингэсэн нөхцөлд бид хурдтай арга хэмжээ. Тэжээл 5 хувийн л татвар байгаа байхгүй юу.

Тэр 5 хувийн татварыг хөнгөлснөөр тэжээлийн хангамж нэмэгдээд байх зүйл байхгүй шүү дээ. Үнийн хувьд нэг их айхтар ачаалал байхгүй байгаа юм. Бид баруун бүс нутгийн мах бэлтгэл дээр онцгой анхаарч бүх бодлогыг чиглүүлж байгаа. Маш сайн худалдан авалт хийж байгаа. Нэгэнт байгаль цаг уурын хүндрэл байгаа үед малчид малаа борлуулах бүх тэр боломжийг нь нээж байгаа. Сайн байгаа. Мал аж ахуйн экспорт одоо бараг 300 сая доллар дөхөж явна.

Д.Үүрийнтуяа: Тодруулъя. Б.Заяабал гишүүн.

Б.Заяабал: Тийм.

Тэгэхээр байгаль цаг уурын хүнд нөхцөл байдалд энэ жил дахиад баруун бүс орж байгаа учраас энэ тогтоолыг дэмжээд явахаас өөр аргагүй болоод байгаа юм.

Ер нь цааш цаашдаа 3 жилд нэг удаа давтагдах байгаль эрсдэлийн зүйлээс хамгаалахын тулд бид газар тариалангаа хөгжүүлэхгүй бол, ялангуяа тэр дундаа баруун аймгийг бүрэн хангадаг байсан Баруунтурууны сангийн аж ахуйг бүрэн дэмжихээс өөр арга байхгүй.

Тийм учраас эргэлтийн талбайг нэмэгдүүлж, тариалалтыг нэмэгдүүлэхийн тулд хамгийн чухал зүйл нь усжуулалтын асуудал болоод байгаа юм. Нэгдүгээр гол асуудал.

Энэ дээрээ та энэ гадаргын усыг ашиглахтай холбоотой Тэс гол гэж байгаа. Тэс голоос наашаа 30-аад километр суваг татаж усжуулах асуудал байгаа. Энэ дээр Та ямар бодлоготой байна гэж асуусан.

Энэ дээрээ Та нэгдүгээрт хариулт өгөөч.

Хоёрдугаарт нь, одоо байгаа хөв цөөрөм, усжуулалтын байгууламжийг чинь нэг хувийн компани хувьчлаад авчихсан. Яс юм дээр хуулиараа бол тэр нь төрд байгаа гээд байгаа. Тэрийг бусад тариалан эрхлэгчид... /минут дуусав/

Д.Үүрийнтуяа: Ж.Энхбаяр сайд хариулъя.

Ж.Энхбаяр: Баруун бүс нутаг маань уулын бүс. Харьцангуй гадаргын ус, газар тариаланг ашиглах бололцоотой тийм нөөц боломжийн байгаа.

Одоо яамнаас 10 ийм усжуулалтын томоохон төсөл хэрэгжиж байгаагийн 7-г нь баруун бүс рүү чиглүүлсэн. 10-аас 7 нь. 3 нь бусад аймгуудад байгаа. Баруун бүс 7 усжуулалтын систем үндсэндээ түрүүчээсээ ашиглалтад ороод хүлээн авч байна. Ирэх жилдээ багтаад ер нь ашиглалтад орно.

Гишүүд Байнгын хороон дээр өгсөн үүрэг, чиглэлийн дагуу мэргэжлийн байгууллагууд оролцоод баруун бүс нутгийн газар тариалан, хөдөө аж ахуйг сэргээх бодлого гаргасан.

- Шаардлагатай төсөвтэй нь,
- хөрөнгөтэй нь,
- усжуулалттай нь,
- газартай нь,
- тарималтай нь асуудлууд бүрэн гарсан.

Одоо хэрэгжүүлэхэд Байнгын хорооны төсвийн дэмжлэг л хэрэгтэй байгаа.

Тэгэхээр бодлого бол тодорхой. Тариаланчидтай газар дээр очиж уулзсан. Монголын хувийн хэвшлийн томоохон компаниуд баруун бүс нутаг руу хөрөнгө оруулалтаа хийхээ илэрхийлээд... /минут дуусав/

Д.Үүрийнтуяа: Дахиад тодруулъя.

Б.Заяабал: Тийм. Тэгэхээр баруун бүс нутаг дээр ганц таатай мэдээ нь хувийн гурилын үйлдвэрүүд байгуулагдах саналууд жишээлбэл Увс аймаг дээр ирсэн байгаа юм билээ.

Тэгэхээр тэр хувийн гурилын үйлдвэрийг хангахын тулд бид найдвартай улаан буудайгаар л хангах ийм үүрэг хүлээж байгаа. Энэ дээр төрийн оролцоо бол ерөөсөө л энэ улаан буудайг нь тасралтгүй хэрэгцээт улаан буудайгаар хангах л үүрэг хүлээж байгаа юм. Тэгэхийн тулд баруун бүсийн Баруунтурууны сангийн сан аж ахуйг буцааж сэргээх зайлшгүй шаардлага байгаа юм.

Хамгийн гол нь усжуулалт нэгдүгээр асуудал.

Хоёрдугаарт нь, төрөөс жоохон санхүүгийн дэмжлэгийн асуудал. Ийм л хоёр зүйл байгаа юм. Энэ дээр Та яамныхаа бодлогод онцгой анхаараарай.

Таван жилийн үндсэн чиглэл дээр үүнтэй холбоотой юмнууд орж ирээгүй учраас би нэмэлт энэ дээр зайлшгүй хэлье гэж бодсон юм.

Тэгээд холбогдох Байнгын хороод дээр нь зарчмын зөрүүтэй санал гаргаад, яамдын зүгээс ороогүй байгаа саналуудыг ирэх таван жилийн үндсэн чиглэлд оруулахад санал санаачилгатай ажиллаарай гэдгийг хүсэх гэсэн юм. Баярлалаа.

Д.Үүрийнтуяа: Гишүүд асуулт асууж дууслаа. /алх цохив/

“Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан санал хэлэх гишүүд байна уу? Санал хэлэх гишүүд байвал нэрсээ өгье.

Ж.Золжаргал гишүүнээр, Б.Мөнхсоёл гишүүнээр тасаллаа. /алх цохив/

Ж.Золжаргал гишүүн саналаа хэлье.

Ж.Золжаргал: Тогтоолын төслийг дэмжиж байгаагаа илэрхийлж байна.

Одоо ингээд өвөлжилт нь хүндрээд, малын тэжээл хэрэгтэй гээд зөвхөн баруун бүсийн тухай ч яриа, асуудал биш байх гэж би бодож байгаа. Сэтгэгдлээ хуваалцъя.

Энэ бол баруун бүсэд л зориулсан тийм тогтоолын төсөл байна л даа.

Ер нь Монгол Улс чинь. Тэр эрчимжсэн мал аж ахуй нэг хэсэг газраа л, төвлөрсөн хэсгүүдээрээ л явна уу гэхээс биш нүүдлийн мал ахуй байдгаараа байж л байна. Ерөөсөө энэ бол ингээд явахаа больчихсон юм. Энэ орчин цаг XXI зуун гээд эсрэг юм ярьдаг болчихоод байгаа юм.

XXI зуунд нүүдлийн мал ахуй байна. Нүүдлийн ахуй амьдралаар амьдарч байгаа хүмүүсийг харин ч XXI зууны технологиор –

- эрчим хүчийг нь хангалттай болгодог,
- усны хангамжийг нь хангалттай болгодог,
- мал амьтанд нь чип суулгадаг,
- цасанд уруудахаар хүн нь үрэгддэггүй,
- боловсролоо зайнаас хангачихдаг,
- эрүүл мэндийн үзлэгээ зайнаас авчихдаг –

-энэ чиглэл рүү бодлого өгүүлэгдэж байгаа.

Жижиг хэмжээний өрхийн болон саахалт айлын түвшинд сүүн бүтээгдэхүүн боловсруулаад, нөгөөх нь гашилж мууддаггүй олон хоногоор хадгалж болдог. Иймэрхүү юмнууд байдаг.

Тэгэхээр энэ дээр бүр нүүдлийн ахуйг XXI зуунд тохируулж хөгжүүлэх хөтөлбөр маягийн юм ер нь цаашдаа хэрэгтэй байгаа гэдгийг хэлэх гэсэн юм.

Б.Уянга гишүүн бид ундны ус, ариун цэврийн байгууламжийн эрх зүйн орчныг сайжруулах тухай гээд ажлын хэсэг дээр ажиллаад санал, дүгнэлт боловсруулсан. Тэгээд явж байхад их сонин юмнууд тааралддаг юм билээ.

Ингээд говьд явж байхад жишээ нь худгийг нь нэмээд, усан хангамжийг нь сайжруулах хэрэгтэй юм байна гээд ярихаар, өө... үгүй.., ингэх юм бол нөгөө бэлчээрийн даац нэмэгдээд бүр их мал. Ус ихтэй болчихоор мал ихтэй болоод болохоо байчихна гээд.

Тэгээд уг нь нэгдүгээрт хүн нь байх ёстой. Цэвэр ус хэрэглэж байх ёстой. Тэр малын тоог бол нэг тийм механик ядуу хэцүү байлгаж байгаад тоог нь бууруулна гэж юм байхгүй шүү дээ.

Тэр нь эсрэгээрээ –

- махны экспортыг нэмэгдүүлэх,
- худалдааг нь чөлөөлөх,
- олдог орлогыг нэмэгдүүлэх замаар л тоогоо бууруулна.

Иймэрхүү байдлаар ер нь хүмүүсийн амьдрал ахуй, малчдыг анхаарч явахгүй бол тэртээ тэргүй үеэ өнгөрөөсөн зүйл гэдэг худлаа бөгөөд XXI зуунд харин ч үнэ цэнд орно гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Үүрийнтуяа: Б.Мөнхсоёл гишүүн саналаа хэлье.

Б.Мөнхсоёл: Ж.Золжаргал гишүүнтэй санал нэг байгаа юм.

Тухайн цаг үеийн нөхцөл байдалд тааруулаад гэнэтийн гэнэтийн байдлаар чухал асуудалд хандаж байснаас бүх л зургаар нь урт хугацаатайгаар иймэрхүү асуудлуудаа ер нь шийддэг болмоор байгаа юм.

Ирэх 5 жилийн Монгол Улсын хөгжлийн үндсэн чиглэл гээд ажлын хэсэгт орж ажиллаж байгаа хүний хувьд мал аж ахуй, хөдөө аж ахуй, тэр дотроо мал аж ахуйн секторын асуудлууд зарим хэсгүүд дээр дутуу дулимаг орсон байна лээ.

Тэгээд үүнтэй уялдуулаад таван жилийн дотор ямар том зорилгод хүрэх юм, хэрхэн хүрэх юм гэдэг зүйлүүдээрээ нарийвчлан цааш цаашдаа анхаарч ажиллах ёстой юм байна лээ шүү гэдгийг л товчхон дурдъя.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа. /алх цохив/

Одоо санал хураалттай тул гишүүд санал хураалтад бэлтгэе. /алх цохив/

“Тогтоолд нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Тогтоолын төслийн хэлэлцэх эсэх 58.6 хувиар дэмжигдлээ.

Протоколд Р.Сэддорж гишүүнийг дэмжсэнээр нэмж тусгая.

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаар Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хамтарсан хуралдааны санал, дүгнэлтийг нэгдсэн чуулганд Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал танилцуулна.

Төсвийн болон Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хамтарсан хуралдаан дууслаа. /алх цохив/

Ажлын хэсэг гишүүдэд талархлаа илэрхийлье.

Одоо Байгаль орчны байнгын хороо үргэлжлээд хуралдана.

Тийм учраас дахин ирц үүсгээд ирцдээ орно шүү гишүүд ээ.

Хамтарсан хуралдаан 23 минут үргэлжилж, 12 цаг 04 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД